



# 2025

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

POST



# Агуулга

<b>4</b>	Мэндчилгээ
<b>6</b>	ТУЗ
<b>8</b>	Алсын хараа
<b>9</b>	Засаглал
<b>10</b>	Компанийн тухай
<b>12</b>	2025 оны онцлох үйл явдал
<b>16</b>	Тайлант оны тойм
<b>22</b>	Бүтээгдэхүүн үйлчилгээ
<b>24</b>	Марк, үнэт цаасны үйлдвэрлэл
<b>28</b>	Хүний нөөц
<b>30</b>	Дунд хугацааны стратеги
<b>32</b>	Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан



Эрхэм ажилтнууд, харилцагчид, хувьцаа эзэмшигчид, хамтрагч байгууллагууддаа Монгол Шуудан ХК-ийн хамт олны нэрийн өмнөөс мэндчилгээ дэвшүүлье. Сүүлийн жилүүдэд дэлхийн шуудан, логистикийн салбар технологийн хурдацтай өөрчлөлт, цахим худалдааны өсөлт, хэрэглэгчийн зан төлөвийн шинэчлэл зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр шинэ шатанд шилжиж байна. Энэ өөрчлөлтийн дунд Монгол Шуудан ХК уламжлалт шуудангийн байгууллагаас илүү өргөн хүрээний логистик, технологид суурилсан үйлчилгээний компани болон хөгжих стратегийг хэрэгжүүлж байна.

### Санхүүгийн тогтвортой байдлыг сэргээж, өсөлтийн суурийг тавилаа

2024 онд компанийн удирдлагын баг бүрэлдэхүүн шинэчлэгдэн ажлаа эхлэх үед Монгол Шуудан ХК санхүүгийн хувьд тодорхой хүндрэлтэй нөхцөлд байсан. Гэсэн хэдий ч бид богино хугацаанд алдагдлыг бууруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр бодит арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд компани 2025 оныг ашигтай дуусгаж, дараагийн өсөлтийн суурийг тавьж чадлаа. Монгол Шуудан ХК нь мөн IPO хийснээс хойш 10 дахь жилдээ дараалан ногдол ашиг тарааж буй төрийн өмчийн оролцоотой компани болж, нийтдээ 3 тэрбум төгрөгийн ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилсан нь компанийн санхүүгийн сахилга бат, засаглалын төлөвшлийг илэрхийлэх чухал үзүүлэлт юм.

### Технологийн шинэчлэл буюу бүтээмжийн дараагийн шат

Бид компанийн ирээдүйн өсөлтийг технологийн шинэчлэл, дэд бүтцийн хөрөнгө оруулалтад тулгуурлан бүтээх зорилготой. Монгол Улсад анх удаа шуудангийн автомат ялган боловсруулах төхөөрөмжүүдийг нэвтрүүлснээр боловсруулах хүчин чадал мэдэгдэхүйц нэмэгдэж, хөдөлмөрийн зардал буурах боломж бүрдлээ. Энэ шинэчлэл нь шуудангийн үйлчилгээний хурд, нарийвчлал, хэрэглэгчийн туршлагыг дараагийн шатанд гаргах суурь болох юм. Мөн бид ухаалаг шуудангийн хайрцаг (EasyBox) төслийг эхлүүлж, хэрэглэгчид илгээмжээ ойрхон цэгээс авах, илгээх, хадгалах боломжийг бий болгож байна. Ойрын жилүүдэд энэ системийг улс даяар өргөжүүлж бүх нийтийн хэрэглээ болгох зорилго тавьсан.

### Цахим худалдаа ба олон улсын логистик

Дэлхийн шуудангийн салбарын хамгийн том өөрчлөлт бол цахим худалдааны хурдацтай өсөлт юм. Монгол Шуудан ХК энэ чиг хандлагад нийцүүлэн цахим худалдааны логистикийн цогц үйлчилгээ үзүүлэгч болох стратегитай ажиллаж байна. Олон улсын цахим худалдааны платформуудтай системийн API холболт бий болгосноор манай үйл ажиллагааны бүтээмж нэмэгдэж, хил дамнасан илгээмжийн урсгал идэвхжиж эхэлсэн. Үүний зэрэгцээ бид өмнө нь зогсоод байсан Хятад-Орос чиглэлийн транзит шуудангийн урсгалыг дахин сэргээж, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх бүс нутгийн логистикийн урсгалыг татах боломжийг нээж гурван улсын эдийн засгийн корридор бодит хувь нэмэр оруулж байна.

### Улсын хэмжээний суурь дэд бүтэц

Монгол Шуудан ХК өнөөдөр 21 аймаг, 330 сум, Улаанбаатарын 22 салбартай улс орон даяар хүрсэн шуудангийн хамгийн өргөн биет сүлжээтэй байгууллага юм. Энэ сүлжээ зөвхөн шуудан хүргэх зориулалттай биш. Цаашид төрийн болон хувийн хэвшлийн олон төрлийн биет болон цахим үйлчилгээг хүргэх үндэсний эко систем болон хөгжих боломжтой.

Иймээс бид сумдын салбаруудыг технологийн шинэчлэлд хамруулж, Android суурьтай POS төхөөрөмжүүд нэвтрүүлснээр:

- шуудангийн үйлчилгээ бодит цагийн горимд шилжих
- санхүүгийн болон даатгалын үйлчилгээ хүргэх
- цахим худалдааг дэмжих үйлчилгээ нэвтрүүлэх боломжийг бүрдүүлээ

### **Бүс нутгийн логистикийн шинэ зангилаа**

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан бид улс орон даяар шуудан, логистикийн дэд төвүүд байгуулах төслийг эхлүүлсэн. Баруун, Хангай, Говь, Зүүн, Хойд, Төвийн бүсүүдэд байгуулагдах эдгээр төвүүд нь агуулах, терминал, тээвэр, шуудангийн дэд бүтцийг нэгтгэсэн логистикийн зангилаа болж, хүргэлтийн хугацааг богиносгох, зардлыг бууруулах, хот хөдөөгийн үйлчилгээний ялгааг багасгахад чухал нөлөө үзүүлнэ.

### **Инновац ба шинэ технологийн туршилт**

Бид шуудангийн салбарыг технологийн хувьд шинэ шатанд гаргах зорилгоор дроны хүргэлтийн туршилтуудыг эхлүүлээд байна. Одоогоор дроны хамгийн боломжит хэрэглээ нь салбар хоорондын дундын (middle-mile) хүргэлт болох нь туршилтаар харагдаж байгаа бөгөөд энэ чиглэлийн судалгаа, туршилтыг үргэлжлүүлэн 2026 онд хийнэ.

### **Засаглалын шинэ соёл**

IPO хийснээс хойших арван жилийн хугацаанд Монгол Шуудан ХК-ийн засаглалын тогтолцоо бодитоор төлөвшиж байна. ТУЗ-ийн бүтэц төр, хувийн хэвшил болон хараат бүс гишүүдийн тэнцвэртэй оролцоонд тулгуурласан бөгөөд гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилдог зарчим нэвтэрсэн. Энэ нь компанийн ил тод байдал, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чухал алхам юм.

### **Ирээдүйн зорилго**

- технологид суурилсан шуудан, логистикийн үйлчилгээ
- хил дамнасан цахим худалдааны дэд бүтэц
- бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээний бодит оролцогч болох
- үндэсний хэмжээний үйлчилгээний платформ болох

Эдгээр зорилго нь Монгол Шуудан ХК-ийг уламжлалт шуудангийн байгууллагаас орчин үеийн логистик, технологийн компани болгон хөгжүүлэх стратегийн дараагийн шат юм.

### **Хамтын өсөлтийн төлөө**

Энэ өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд манай ажилтан бүрийн хичээл зүтгэл, харилцагч байгууллагуудын итгэл, хөрөнгө оруулагчдын дэмжлэг чухал үүрэгтэй. Монгол Шуудан ХК цаашид ч улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үндэсний дэд бүтцийн компани байж, шинэ үеийн логистикийн шийдлүүдийг нэвтрүүлэхийн төлөө түүштай ажиллана.

Та бүхнийг хүндэтгэсэн,

**Хонгор овогт Гэрэлтийн Тэлмэн**

Гүйцэтгэх захирал

## Төлөөлөн удирдах зөвлөл



ТУЗ-ийн дарга, ТӨБЗГ, Төрийн өмчийн  
бүртгэл хяналтын хэлстийн дарга  
**Д.Нарангэрэл**



**О.Одбаяр**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
Ард Даатгал ХК ТУЗ-ийн  
дарга



**Д.Дэлгэрмаа**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
ТӨБЗГ-ын Хууль зүйн  
албаны дарга



**Г.Уянга**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
"Ард пропертив" ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



**Д.Балжинням**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
ЗГХЭГ-ын Салбарын бодлого,  
зохицуулалтын газрын Засгийн  
газрын ахлах референт



**Х.Сүрэнхорол**

ТУЗ-ийн ердийн гишүүн,  
УИХ-ын Тамгын газрын  
Хуулийн газрын дарга



**Д.Балдорж**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,  
Хилийн боомтын захиргаа,  
Боомтын үйл ажиллагааны  
хэлтсийн дарга



**Ч.Амарбаатар**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,  
Барс группын тэргүүн



**Б.Ганбаатар**

ТУЗ-ийн хараат бус гишүүн,  
өмгөөллийн "Монгол элч  
консалтинг" ХХК-ийн зөвлөх

MONGOL POST  
DPX

01

10

20

02

11

21



☎ 1800-1613

12

22

MONGOL POST DPX

03

13

23

04

14

24

05

15

25

06

16

26

07

17

27

08

18

28

09

19

29

☎ 1800-1613  
[www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)

ШУУДАН  
INTERNATIONAL MAIL

## АЛСЫН ХАРАА


Өдөр бүр уулзах үндэсний  
шилдэг компани

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн дэвшилтэт технологид хүрсэн,  
чанартай, цогц үйлчилгээгээр хүн бүрийн  
шуудангийн хэрэгцээг төгс хангах нь  
бидний эрхэм зорилго юм.

## ҮНЭТ ЗҮЙЛ

Хэрэглэгчээ дээдлэх  
Өндөр бүтээмж  
Мэргэшсэн баг  
Түргэн шуурхай  
Тасралтгүй сайжруулалт  
Найдвартай түнш



## МОНГОЛ ШУУДАНГИЙН ТҮҮХ 1921-2025



Шуудан харилцааны уламжлал Монголын түүхэнд гүн үндэстэй. Түүний эх сурвалжийг Хүннү гүрний үеэс эхтэй гэж үздэг боловч илүү тодорхой зохион байгуулалттай систем нь XIII зуунд бий болсон юм. Их эзэн Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгэдэй хаан төр барьж байх үед (1228-1241) Монголын эзэнт гүрний захиргаа, мэдээллийн урсгалыг хурдан шуурхай дамжуулах зорилгоор морин өртөөний сүлжээ байгуулсан нь шуудан харилцааны хөгжилд томоохон дэвшил болсон.

“Монголын морин өртөө” хэмээн алдаршсан энэ тогтолцоо нь эзэнт гүрний өргөн уудам нутаг дэвсгэрт мэдээ, зарлиг, захидал дамжуулах нэгдсэн сүлжээг бий болгож, тухайн үеийн дэлхийн хамгийн хөгжингүй харилцаа холбооны системүүдийн нэгэнд тооцогдож байв. Өгэдэй хаан энэ тогтолцоог төрийн зохион байгуулалтын чухал шинэчлэл болгон хөгжүүлсэн нь түүхэнд “дөрвөн сайн үйл”-ийн нэгээр тэмдэглэгдэн үлджээ.

Цаг хугацааны явцад өртөөний тогтолцоо улам боловсронгуй болсоор, XX зууны эхэнд орчин үеийн шуудангийн байгууллагын үндэс суурь тавигдсан. Тухайлбал, 1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын Тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол Улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороо байгуулагдсан нь өнөөгийн зуун жилийн түүхтэй Монгол Шуудан байгууллагын эхлэл болсон юм.

1921.07.19

Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол Улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулав.

1935

Нийслэлийн шуудангийн хороо

1935-1936

Нийслэлийн Төв холбооны Төв шуудангийн тасаг



1936-1958

Холбооны Ерөнхий Хорооны харьяа Төв шуудан



1958-1960

Цахилгаан Шуудангийн хороо

1966-1978

Төв шуудан



1978-1990

Цахилгаан Шуудан Холбооны газар



1990-1994

Шуудан холбооны газар

1994

Монгол Шуудан ТӨҮГ



2002

Монгол Шуудан ХХК

2009

Монгол Шуудан ТӨХК



2016

Монгол Шуудан ХК

# 1.

“YTO Express” болон “DPX logistics” компанийн удирдлагууд Монголд айлчилж, стратегийн хамтын ажиллагааг эхлүүлж, Taobao болон PDD цахим худалдааны тендерт шалгарч хамтын ажиллагаа өргөжүүлэв.



# 2.

Монгол шуудангийн дэд бүтцийг шинэчлэх зорилготой Японы МИС дэд бүтцийн төслийг эхлүүллээ.



# 3.

Шүүхийн байгууллагуудад зориулсан “Hybrid Mail” модуль хөгжүүлж 14 шүүхэд нэвтрүүлэв.



# 4.

Монгол шуудан Phila Korea 2025 олон улсын маркийн үзэсгэлэнд амжилттай оролцов.



# 5.

“People in need” ОУБ-тай хамтран ой, хээрийн түймэртэй байгаа Хэнтий аймгийн 4 суманд 2 удаа тусламжийн барааг хүргэлээ.



# 6.

21 аймаг, 311 суманд POS төхөөрөмж нэвтрүүлж шуудангийн үйлчилгээ дижитал болгох ажлыг эхлүүлэв.



# 7.

Дрон хүргэлтийн туршилт эхлүүлэв. Монгол шуудан ХК шинэ технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд дроны хүргэлтийн туршилтыг “Ньюком” компанитай хамтран амжилттай хэрэгжүүлээ. Энэ нь Монголд логистикийн шинэ шийдлийг турших эхний алхам болсон.



# 8.

Бүсийн логистикийн дэд төвүүд байгуулах төслийг нээж, зураг төсөл боловсруулав.



# 9.

Нээлттэй хаалганы өдөрлөг 300 гаруй хүн оролцож хайртай дотнын хүндээ үнэ төлбөргүй захиа илгээв. Оролцогчид маркийн музей үзэж сонирхон судалгаанд хамрагдав. Нээлттэй хаалганы өдөрлөгт нийтдээ 300 гаруй иргэн оролцож, шуудангийн үйлчилгээ, шинэ технологитой танилцлаа.



# 10.

Omniva /Эстони шуудантай хамтран АНУ-аас худалдан авалт хийх виртуал хаягийн үйлчилгээ нэвтрүүлэв.



# 11.

Ерөнхий сайдын 837,540 ш захидлыг Орон нутаг, Налайх, Багахангай, Багануур дүүрэгт хүргэлээ.



# 12.

"EasyBox" ухаалаг шуудангийн хайрцагийн төсөл эхлэв.



# 13.

Temu, Aliexpress, Taobao зэрэг олон улсын цахим худалдааны платформуудын Монгол шуудангаар дамжих хүргэлт өслөө.



# 14.

Автомат ялган боловсруулах систем нэвтрүүлэв (Бичиг захидал, боодол).



# 15.

Агаарын ялган боловсруулах төвд Дэлхийн шуудан холбооны (ДШХ) аюулгүй байдлын S58, S59 стандартыг хангаж, 2025 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр стандартад нийцсэн болохыг баталгаажуулан Аюулгүй байдлын алтан сертификат авав.



# 16.

Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо болж өнгөрсөн Дэлхийн Шуудангийн Холбооны (UPU) XXVIII Конгресст анх удаа оролцов. Энэхүү Конгрессын үеэр Монгол Улс түүхэндээ анх удаа ДШХ-ны Шуудангийн үйл ажиллагааны зөвлөлд (POC)-д ажиллахаар сонгогдов.



# 17.

Ази, номхон далайн шуудангийн холбооны (APPU) гүйцэтгэх зөвлөлийн хурал Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдаж, 50 гаруй улс, 100 гаруй төлөөлөгчийг хүлээн авлаа.

# 2025

Монгол Шуудан ХК юуг өөрчилж чадсан бэ?



## Сонголтын жил

2025 оны эхэнд Монгол Шуудан ХК чимээгүй боловч стратегийн хувьд шийдвэрлэх сонголтууд хийсэн. Өсөлтийн хурдыг хөөх үү, эсвэл ашигт ажиллагааны сууриа батжуулах уу? Цахим худалдаа тэлж, хил дамнасан урсгал эрчимжиж, хэрэглэгч илүү хурд, илүү ил тод байдал шаардах болсон энэ үед шуудангийн операторын хувьд зөвхөн илгээмжийн тоо нэмэх нь хангалтгүй байлаа. Суурь бүтэц, процесс, системийн чадавх өөрчлөгдөхгүй бол өсөлт нь өөрөө эрсдэл болж хувирна. Ийм нөхцөлд 2025 оны стратеги “хэмжээг” бус “чанарыг”, “түргэн өсөлтийг” бус “тогтвортой ашигт ажиллагааг” зорьсон жил байв. Үйл ажиллагааны үр ашиг, дижитал шилжилт, бизнес өргөжилтийн гурван тулгуурт суурилсан энэхүү чиглэл нь компанийн дотоод бүтцийг шинэ шатанд гаргах зорилготой байлаа.

## Саалиа бэлдэхээр саваа бэлд

Логистикийн салбарт өсөлтийг даах цорын ганц арга бол хүчин чадлаа урьдчилан бэлтгэх явдал. 2025 онд ялган боловсруулах хүчин чадлыг 5 дахин нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлж, автоматжуулалтын шат дараалсан шинэчлэлийг эхлүүлэв. Тав дахин өссөн хүчин чадал нь зөвхөн техник тоног төхөөрөмжийн шинэчлэл бус, ирэх жилүүдийн урсгалыг даах системийн суурь өөрчлөлт байлаа. Терминалын зохион байгуулалт, ялгалтын процесс, машинт хүргэлтийн тоог нэмэгдүүлэх зэрэг шийдлүүд нь зөвхөн дотоод зохион байгуулалтын өөрчлөлт биш, харин ирээдүйн урсгалыг даах архитектурын бэлтгэл байв.

2025 онд илгээмж, боодлын автомат машин нь 48 шугамаар зэрэг ажиллаж, цагт 3,000–3,600 илгээмжийг 99.9%-ийн нарийвчлалтай ялгах боломж бүрдүүлсэн бол бичиг захидлын автомат машин 60 шугамаар цагт 1,500–2,000 ширхгийг 98%-ийн нарийвчлалтай ангилж байна. Ингэснээр буруу ялгах магадлал 0.01% хүртэл буурч, ажиллах хүчний зардал хоёр дахин багассан нь хүчин чадлыг өсөлтийг нотолж буй нэгэн үзүүлэлт юм.

Түүнчлэн, нэг ажилтны бүтээмж 2023 онд 1.6 сая төгрөг орчим байсан бол 2025 онд 2.7 сая төгрөгт хүрч, 69 хувь өссөн нь процессын оновчлол, автоматжуулалтын шууд үр дүн байлаа. Энэхүү өсөлт нь хүний нөөцийн ачасаллыг нэмэгдүүлэх бус, бүтцийн үр ашгийг дээшлүүлсэн стратегийн шийдвэрийн илэрхийлэл болсон юм. Энэ өсөлт нь зардал танах замаар бус, илүү ухаалаг зохион байгуулалтын үр дүнд бий болсон гэдгээрээ онцлог.

Ийнхүү машинт хүргэлтийн өргөтгөл, маршрут оновчлол, ялган боловсруулах хурд нэмэгдсэн нь нийт сүлжээний гүйцэтгэлийг жигд болгож, хот хооронд болон хот доторх урсгалын найдвартай байдлыг дээшлүүлэв.



## Цахим шилжилт ба датад суурилсан шийдэл

Орчин үеийн шуудан бол зөвхөн физик урсгал биш, мэдээллийн урсгал юм. 2025 онд компанийн гол системүүдийн архитектурыг шинэчилж, ePostNet болон MyDelivery системүүдийг өргөтгөн хөгжүүлж, нийт 53 API интеграц хийсэн нь мэдээллийн солилцоог хурдтай, найдвартай болгосон. Ингэснээр дотоод болон гадаад системүүдийг уялдуулсан дата солилцооны шинэ түвшинг үүсгэж, компанийн дижитал архитектурыг илүү нээлттэй, өргөтгөх боломжтой болголоо.

Тухайлбал, гаалийн системтэй интеграц хийж, олон улсын IPS системд шинэчлэлт хийсэн зэрэг нь хил дамнасан урсгалын ил тод байдлыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн хүлээлтийг хангах дижитал суурийг тавив. Датад суурилсан маршрут оновчлол, хэрэглэгчийн зан төлөвийн анализ хийх боломж бүрдсэн нь зөвхөн технологийн

шинэчлэл бус, удирдлагын шийдвэр гаргалтыг чанарын шинэ түвшинд хүргэж байна.

Хэрэглэгчийн талд AI chatbot, Track & Trace үйлчилгээний шинэчлэл, веб сайтын сайжруулалт зэрэг нь “асууж лавлах” загвараас “өөрөө хянах” загварт шилжих эхлэл болов. Энэ нь хэрэглэгчийн туршлагыг сайжруулахаас гадна, дотоод зардлыг бууруулах стратегийн ач холбогдолтой.

Сумын түвшинд гэвэл 311 суманд POS төхөөрөмж суурилуулан олон төрлийн үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлж буй нь Монгол Шуудан ХК-ийн сүлжээг дижитал болон физик хосолсон (PHYGITAL) үндэсний оператор болгон хувиргаж байна.

## Бизнес өргөжилт ба шинэ урсгал

2025 онд Монгол Шуудан ХК хил дамнасан цахим худалдааны стратегийн байр сууриа бодитоор бататгалаа. Бид Хятадын Шуудан, Оросын Шуудан болон БНХАУ-ын логистикийн аварга YTO Express, DPX компаниудтай хамтын ажиллагаагаа шинэ шатанд гаргав. Ингэснээр Temu, Taobao, AliExpress, Pinduoduo, Ozon-оос ирсэн 552,000 гаруй илгээмжийн гаалийн бүрдүүлэлтийг гүйцэтгэн, Монгол орны өнцөг бүрт саадгүй хүргэлээ.

Энэ бол зөвхөн тоо биш. Жилд дунджаар 2.5 сая илгээмж дамжуулан хүргэдэг манай сүлжээнд хил дамнасан цахим худалдааны урсгал нэмэгдсэнээр, зөвхөн энэ шинэ төрлийн үйлчилгээнээс 1.5 тэрбум төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж чадлаа. Өмнө нь байгаагүй энэхүү шинэ эх үүсвэр нь манай "Худалдааны платформ"-ын хүргэлтийн шийдэл болон хөгжих алсын хараа бодитой хэрэгжиж, монгол хүний хүсэл, хэрэгцээг дэлхийн зах зээлтэй холбосон найдвартай гүүр нь байж чадсаны баталгаа юм.

Шуудан ялгах хүчин чадал нэмэгдсэн нь бизнес өргөжилтийн бодит суурь болж өгсөн юм. Энэ өсөлт нь зөвхөн дотоод гүйцэтгэлийг сайжруулаад зогсохгүй, транзит болон цахим худалдааны урсгал огцом нэмэгдэх үед сааталгүй, найдвартай боловсруулж дамжуулах чадавхыг бүрдүүлсэн стратегийн дэд бүтэц болж байна. Үүнээс гадна, БНХАУ-ОХУ чиглэлийн транзит урсгалын коридор тэлж, 409,185 кг транзит ачааг дамжуулсан нь Монгол Улсыг бүс нутгийн логистикийн зангилаа болгох стратегийн эхлэл гэж болно. Энэхүү урсгал нь Монгол Шуудан ХК-ийн транзит операторын чадавх бодитоор тэлж байгааг илтгэнэ.



## Хүчин чадал, бүтээмж



Стандарт агуулах терминал (Fulfilment centre)



Ялган боловсруулах процессыг автоматжуулсан



Машинтай хүргэлтийн тоог нэмэгдүүлсэн

## Цахим шилжилт эрчимжүүлэх, инновац нэвтрүүлэх



Датанд суурилсан хэрэглэгчийн үйлчилгээ (UX), хүргэлтийн оновчлол (Route optimization) бий болгосон



Дроны хүргэлтийн туршилт (ДШХ-с ТЭЗҮ боловсруулах төсөлд хамруулав)



Гадаад, дотоодын цахим худалдааны платформтой API холболт хийсэн



Бүх сумдад POS нэвтрүүлсэн /330 Цахим сум/

## ҮР ДҮН

- Ялгах хүчин чадал 5 дахин
- Нэг ажилтны бүтээмж /+69%/
- Сумын түвшинд төрийн болон хувийн хэвшлийн цахим үйлчилгээг үзүүлэх боломж /орлогын төрөлжилт/

2023 онд 1.6 сая  
2025 онд 2.7 сая

## Хэрэглэгч төвтэй шинэчлэл

Эцсийн дүндээ аливаа стратеги хэрэглэгч дээр л шалгагддаг. 2025 онд Call center-ийн шинэчлэл, веб сайтын сайжруулалт, Track & Trace үйлчилгээний өргөтгөл, гараас гарт хүргэх процессын оновчлол зэрэг нь хэрэглэгчийн туршлагыг стратегийн төвд тавьсан шийдлүүд байлаа.

Монгол Шуудан ХК “сүлжээ” гэхээс илүү “туршлага” (experience)-ийг санал болгодог байгууллага болох зорилго тавьж, үйлчилгээний хүртээмж, хурд, ил тод байдлыг зэрэг ахиулж байна. Энэ бол зөвхөн технологийн шинэчлэл биш, бизнес загварын шинэчлэл юм.



**MONGOL  
POST**

## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

### МАРК, ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА

- Маркийн үйлдвэрлэл, худалдаа
- Дугтуй, бланк, хэвлэмэл материалын үйлдвэрлэл, худалдаа
- Ил захидал, мэндчилгээ, бусад бүтээгдэхүүний борлуулалт

### ДОТООД ШУУДАН, ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Хот доторх болон хот хоорондын хүргэлт
- Логистик үйлчилгээ
- Хэвлэл захиалга, хүргэлт
- Гараас гарт хүргэлт

### ГАДААД ШУУДАН, ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Улс хоорондын шуудан
- Гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ

### БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

- Санхүүгийн үйлчилгээний агент
- Сурталчилгааны материал тараах үйлчилгээ
- Түрээсийн үйлчилгээ

### БҮС НУТГИЙН ТРАНЗИТ ТЭЭВЭР

- ОХУ, БНХАУ хооронд улс хоорондын тээвэр



### ГАРААС ГАРТ ХҮРГЭЛТ

Илгээмжийг захиалга өгсөн хаяг дээрээс очиж хүлээн авч, хаягийн дагуу Улаанбаатар хотод 8-24, орон нутагт 12-48 цагийн дотор хурдан шуурхай, найдвартай гараас гарт хүргэнэ.



### БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ШУУДАН

Бид дотоодын болон олон улсын бүх төрлийн илгээмж, албан бичиг хүргэлтээс гадна нийт 30 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээг дараа төлбөрөөр хамтран ажиллах, хүссэн үедээ шуудангийн үйлчилгээг дараалал, чирэгдэлгүй авч хамтран ажиллахыг урьж байна.



### ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРГЭЛТ

Төрийн нэгдсэн портал болох [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn) -ээр шуудангийн өргөн сүлжээгээрээ дамжуулан

- Иргэдийн жолооны үнэмлэх,
- Иргэний үнэмлэх,
- Гадаад паспортоос эхлээд

60 гаруй үйлчилгээг хаягийн дагуу баталгаатай, түргэн шуурхай хүргэж ажиллана.



### ХОТ ХООРОНДЫН ТЭЭВЭР, ЛОГИСТИК

“Монгол шуудан” ХК нь 21 аймагт ачаа тээврийн үйлчилгээг 7 хоног бүр тогтмол явуулдаг. Мөн үйлчлүүлэгчийн цаг завьг хэмнэж таны хүсэлтийн дагуу Улаанбаатар хот дотор хүссэн хаягаар хүргэнэ.



### ШУУД МАРКЕТИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Сурталчилгааны материал, танилцуулга зэрэг хэвлэмэл материалыг манайхаар дамжуулан зорилтот хэрэглэгчид болон сонин хэвлэл тогтмол захиалдаг байгууллага хувь хүмүүст шуудангийн өргөн сүлжээгээрээ дамжуулан Монгол орны өнцөг булан бүрд хүссэн зах зээлийн хүрээнд, баталгаатай, түргэн шуурхай хүргэнэ.


# МАРК, ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ





2025 онд Марк, үнэт цаасны хэлтэс нь 29 сэдвийн шинэ марк, 130,000 гаруй ширхэг үнэт цаасны бүтээгдэхүүн, олон улсын 1 том үзэсгэлэн, дотоодын 4 удаагийн сургалт зохион байгуулж, маркыг соёлын бүтээгдэхүүн, экспортын боломжтой үнэт контент болгон хөгжүүлэхэд бодит ахиц гаргалаа.

## 1. Онцлох шинэ марк





## 2. Онцлох анхны өдрийн дугтуй



### 3. Онцлох мөнгөний дугтуй



## Хүний капиталын тогтвортой хөгжлийг бэхжүүлнэ

2025 онд хүний нөөцийн бодлого нь зөвхөн бүрдүүлэлт, захиргааны чиг үүрэгт төвлөрөх бус, ажилтны сэтгэл зүй, эрүүл мэнд, оролцоо, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжсэн соёлын бодлого болон өргөжсөн, нэгж ажилтны бүтээмжийг нэмэгдүүлсэн жил байлаа.

### Бүтээмжийг нэмэгдүүлэв

2025 онд нийт 950 ажилтантайгаар ажилласан бөгөөд ажиллах хүчний бүтэц харьцангуй тогтвортой хадгалагдаж, боловсролын түвшнээр нь авч үзвэл дээд боловсролтой ажилтнууд 28 хувь, бүрэн дунд боловсролтой 42 хувь, тусгай дунд боловсролтой 30 хувийг эзэлж байна. Харин хүйсийн харьцааны тал дээр 20 хувь нь эрэгтэй, 80 хувь нь эмэгтэй ажилтан ажиллаж байна. Компанийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны оновчлолыг тодорхойлох, бүтээмжийг нэмэгдүүлэх, хүрээнд хийгдсэн ажлын хүрээнд оновчлолыг сайжруулах ажлуудыг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд 2025 онд нэг ажилтанд ногдох орлогыг нэмэгдүүлж, нэг ажилтны бүтээмжийг 30 хувь нэмэгдүүлсэн.

Цалин хөлсний хувьд Монгол Шуудан ХК-ийн нийт ажилтнуудын дундаж цалин Монгол улсын болон салбарын дунжаас доогуур явж ирсэн билээ. Энэ нь нэгж ажилтны бүтээмжтэй шууд холбоотой. 2024 болон 2025 онуудад бүтээмжийг нэмэгдүүлэх оновчлолыг зөв хэрэгжүүлснээр 2023 онтой харьцуулахад тайлант хугацаанд бүтээмжийг 69%-р нэмэгдүүллээ. Улмаар энэхүү тайлан хүрэх цаг мөчид нийт ажилтнуудын цалинг дунджаар 30 хувиар нэмэгдүүлж чадлаа (2025 оны 4 сар 01 өдөр +20%, 2026 оны 2 сарын 01 өдөр +10%). Компанийн бүтээмжийг нэмэгдүүлж ажилтнуудын цалинг нэмэгдүүлж, ар гэрийн баталгааг хангах нь цаашид ч компанийн хувьд тэргүүн зорилтын гэрийн даалгавар байх болно.



### Ажилтны тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллав

Тайлант хугацаанд хүний нөөцийн боловсрол, үр чадварыг дэмжих чиглэлд шат дараатай ажилласан нь байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэхэд чиглэв. Хүний нөөцийн бодлогын нэг чухал чиглэл нь ажилтны үр чадварыг нэмэгдүүлэх, ажилтны сэтгэл зүйн эрүүл мэнд, ажил амьдралын тэнцвэрийг дэмжих, мэдээллийн урсгалыг сайжруулах явдал байлаа.

- Тайлант хугацаанд 25 ажилтанг АРПУ, БНЭУ, БНХАУ-ын 100 тэтгэлэгт хамруулан сургав.
- “А Star” сургалтын төвтэй хамтран англи хэлний сургалтыг эхлүүлж, 23 ажилтан хамруулан ажилтны хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллав.
- Ажилтны сэтгэл зүйн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, ажилтнуудын сэтгэл зүйн дархлаа, ажил амьдралын тэнцвэрийг хангаж ажиллахад анхаарч ажиллаа.
- Мэдээллийн ил тод байдлыг хангах, нэгдмэл ойлголт, мэдээллийг бүрдүүлэх хүрээнд сар бүр компанийн үйл ажиллагаатай холбоотой онцлох мэдээг бэлтгэн нийт ажилтнуудад сар бүр хүргэж ажиллаа.
- хүрээнд спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж, салбарын болон байгууллагын түвшний тэмцээнүүдэд амжилттай оролцлоо. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын спорт наадам, ARD CUP-2025 тэмцээнүүдэд багийн амжилтаар шагналт байр эзэлсэн нь хамт олны уур амьсгал, багийн сэтгэлгээг бэхжүүлсэн. Ийнхүү 2025 онд хүний нөөцийн бодлого нь зөвхөн бүрдүүлэлт, захиргааны чиг үүрэгт төвлөрөх бус, ажилтны сэтгэл зүй, эрүүл мэнд, оролцоо, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжсэн соёлын бодлого болон өргөжсөн жил байлаа. Байгууллагын хөгжлийн дараагийн шатанд хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэдлэгт суурилсан менежментийг бэхжүүлэх нь стратегийн гол чиглэл хэвээр байна.

Компанийн дэргэдэх ахмадын хороонд байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан 272 ахмад ажилтан бүртгэлтэй байгаа бөгөөд компанийн зүгээс ахмад ажилтнуудад чиглэсэн дэмжлэг туслалцаа, үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж ажиллаж байгаа нь нийгмийн хариуцлагыг бодитой хэрэгжүүлж буйг илтгэнэ.



## Ойрын 3 жилд манай компани юунд зорьж байна вэ?

**Ирэх жилүүдэд компанийн амжилтын хэмжүүр нь зөвхөн илгээмжийн тоо биш, харин сүлжээний үнэ цэн, өгөгдөл, хурд, интеграцийн чадамж байх болно.**

2025–2028 оны дунд хугацаанд Монгол Шуудан ХК өөрийн бизнесийн загварыг шинэ шатанд гаргах стратеги хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэхүү стратегийн үндсэн зорилго нь уламжлалт шуудангийн үйлчилгээний хүрээнээс давж, үндэсний хэмжээний логистик болон цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ компани болон хөгжихөд оршино.

Өнгөрсөн жилүүдэд зах зээлд гарсан хамгийн том өөрчлөлт бол цахим худалдаа, төрийн цахим үйлчилгээ, санхүүгийн дижитал шилжилт хурдацтай өссөн явдал байлаа. Иргэд, бизнес эрхлэгчид үйлчилгээний хурд, хүртээмж, найдвартай байдалд илүү өндөр шаардлага тавих болсон. Энэ нөхцөлд Монгол Шуудан ХК-ийн өргөн салбар сүлжээ, орон нутгийн хамрах хүрээ нь стратегийн чухал давуу тал болж байна.

Ирэх гурван жилд компани нийт борлуулалтаа 23.6 тэрбум төгрөгөөс 52 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байна. Энэ нь 220 хувийн өсөлт юм. Гэхдээ стратегийн гол зорилт нь зөвхөн орлого нэмэх бус, ашигт ажиллагааг эрс сайжруулахад чиглэж байна. 2024 онд 0.1 тэрбум төгрөг байсан цэвэр ашгийг 2028 онд 4 тэрбум төгрөгт хүргэх зорилт дэвшүүлсэн нь 1,178 хувийн өсөлт гэсэн үг. Энэ нь бизнесийн бүтцийг өөрчилж, илүү өндөр өгөөжтэй үйлчилгээний жинг нэмэгдүүлэх, зардлын удирдлагыг шинэ шатанд гаргах замаар хэрэгжинэ.

Мөн компанийн өөрийн хөрөнгийн өгөөжийг 1.3 хувиас 13 хувьд хүргэх зорилт тавьсан. Энэ бол хувьцаа эзэмшигчдийн хувьд хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Өөрөөр хэлбэл, компанийн хөрөнгө илүү үр ашигтай ажиллаж, капиталын өгөөж эрс нэмэгдэх төлөвтэй байна.

Стратегийн хүрээнд Монгол Шуудан ХК төрийн цахим үйлчилгээний хүргэлтийн үндсэн суваг болж ажиллана. Орон нутгийн салбарууд маань зөвхөн шуудангийн үйлчилгээ үзүүлэхээс гадна төр, хувийн хэвшлийн цахим үйлчилгээг иргэдэд ойртуулах төв цэг болж хөгжих юм. Энэ нь орон нутгийн иргэдэд үйлчилгээний зардал, цаг хугацааг бууруулна.

Цахим худалдааны салбарт компани агуулах, ангилан ялгалт, түгээлт, буцаалтын нэгдсэн шийдлийг санал болгох замаар худалдаасчид болон жижиг бизнес эрхлэгчдэд логистикийн найдвартай түнш болно. Орон нутгийн хүргэлтийн хурдыг 5 дахин нэмэгдүүлэх зорилт нь жижиг, дунд бизнесийн өрсөлдөх чадварт шууд эерэг нөлөө үзүүлнэ.



Бүс нутгийн хэмжээнд хил дамнасан цахим худалдааны транзит тээврийн сүлжээг хөгжүүлэх нь стратегийн дараагийн чухал чиглэл юм. Монгол Улсын газарзүйн байрлал нь Зүүн Хойд Азийн логистикийн зангилаа болох боломжийг олгодог. Энэ боломжийг ашиглан дамжин өнгөрөх шуудан, илгээмжийн урсгалыг нэмэгдүүлэх нь компанийн орлогын шинэ эх үүсвэр болно.

Нийгэм, эдийн засгийн түвшинд энэхүү стратеги нь хот, хөдөөгийн үйлчилгээний ялгааг багасгаж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зэрэг өргөн хүрээний эерэг нөлөөг бий болгоно. Энэ нь компанийн нийгмийн хариуцлагын бодлоготой уялдаж байна.

Эцэст нь хэлэхэд, 2025–2028 оны стратеги нь Монгол Шуудан ХК-ийг уламжлалт шуудангийн байгууллагаас илүү өргөн хүрээний дижитал логистикийн сүлжээ компани болгон өөрчлөх зорилготой. Энэхүү өөрчлөлт нь борлуулалт, ашигт ажиллагаа, капиталын өгөөжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувьцаа эзэмшигчдэд урт хугацааны тогтвортой үнэ цэнийг бий болгоход чиглэж байна.

Ирэх жилүүдэд компанийн амжилтын хэмжүүр нь зөвхөн илгээмжийн тоо биш, харин сүлжээний үнэ цэн, өгөгдөл, хурд, интеграцийн чадамж байх болно. Энэ бол өсөлтийн дараагийн шатанд шилжих бодит алхам юм.



Төрийн цахим үйлчилгээний хүргэлтийн үндсэн сүлжээ байх



Цахим худалдааны хүргэлтийн цогц үйлчилгээ үзүүлэгч сүлжээ болох



Орон даяар шуудан - логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох



Бүс нутгийн хил дамнанас цахим худалдааны транзит тээвэрлэгч болох



## Нийгэм, эдийн засгийн үр өгөөж

- Орон нутгийн жижиглэн худалдааны шуудан тээврийн хүргэлтийн хурдыг 5 дахин нэмэгдүүлнэ
- Улаанбаатар хотын замын ачааллыг 10% бууруулна
- Төр, хувийн хэвшлийн байгууллагын цахим үйлчилгээг сумын түвшинд хамгийн бага зардлаар хүргэх сүлжээ болно
- Орон нутгийн иргэдэд хүрэх санхүүгийн үйлчилгээний өртгийг бууруулна
- Дамжин өнгөрөх транзит шуудангийн сүлжээ бэхжих
- Хот хөдөөгийн бараа бүтээгдэхүүний үнийн ялгааг ойртуулах

## Компанийн үр өгөөж

(2025-2028 оны дунд хугацааны стратеги зорилт)

Нэгж: тэрбум



Борлуулалтын орлого 2028 он/2024 он

+220%

Цэвэр ашиг 2028 он/2024 он

+1,178%

Нэг ажилтны бүтээмж 2028 он /сэтгэл ханамжтай ажилтан/

4.4 сая

ROE /эздийн өмчийн өгөөж/

2024 онд 1.3%  
2028 онд 13%

# Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа : 2025-01-01 - 2025-12-31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1 ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1 Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,747,302,178.00	8,943,566,851.61
1.1.2 Дансны авлага	5,487,178,266.86	5,410,316,253.85
1.1.3 Татвар, НДШ - ийн авлага	36,704,950.48	164,421,547.67
1.1.4 Бусад авлага	322,059,493.58	201,982,073.83
1.1.5 Бусад санхүүгийн хөрөнгө	0	0
1.1.6 Бараа материал	4,417,731,167.56	4,257,717,768.16
1.1.7 Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,529,320,145.79	431,323,802.27
1.1.8 Бусад эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.9 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0	0
<b>1.1.10 Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>25,540,296,202.27</b>	<b>19,409,328,297.39</b>
<b>1.2 Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>
1.2.1 Үндсэн хөрөнгө	9,441,368,255.49	13,553,463,732.21
1.2.2 Биет бус хөрөнгө	2,047,471,887.52	2,594,049,775.53
1.2.3 Биологийн хөрөнгө	0	0
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт	500,000.00	500,000.00
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0	0
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө	0	0
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0	0
1.2.9 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0	0
<b>1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>11,489,340,143.01</b>	<b>16,148,013,507.74</b>
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,029,636,345.28</b>	<b>35,557,341,805.13</b>

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2 ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>2.1 Өр төлбөр</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>2.1.1 Богино хугацаат өр төлбөр</b>	<b>0</b>	<b>0</b>
2.1.1.1 Дансны өглөг	9,241,178,117.76	8,324,391,133.22
2.1.1.2 Цалингийн өглөг	313,398,175.31	285,490,417.89
2.1.1.3 Татварын өр	14,531,702.64	34,992,892.19
2.1.1.4 НДШ - ийн өглөг	9,467,299.76	0
2.1.1.5 Богино хугацаат зээл	0	0
2.1.1.6 Хүүний өглөг	0	0
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг	0	0
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	903,726,893.62	768,509,032.83
2.1.1.9 Нөөц /өр төлбөр/	0	0
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	922,668,661.93	289,248,851.53
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	0	0
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,404,970,851.02</b>	<b>9,702,632,327.66</b>
<b>2.1.2 Үрт хугацаат өр төлбөр</b>	<b>0</b>	<b>0</b>
2.1.2.1 Үрт хугацаат зээл	0	0
2.1.2.2 Нөөц /өр төлбөр/	0	0
2.1.2.3 Үрт хугацаат бондын өглөг	0	0
2.1.2.4 Хойшлогдсон татварын өр	0	0
<b>2.1.2.6 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>2.2 Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>11,404,970,851.02</b>	<b>9,702,632,327.66</b>
<b>2.3 Эздийн өмч</b>	<b>0</b>	<b>0</b>
2.3.1 Өмч: - төрийн	6,572,700,000.00	6,572,700,000.00
2.3.2 - хувийн	3,385,936,300.00	3,385,936,300.00
2.3.3 - хувьцаат	0	0
2.3.4 Халаасны хувьцаа	0	0
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал	2,538,512,210.45	2,538,512,210.45
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,379,919,523.85	3,379,919,523.85
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0	0
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	3,714,085,782.53	3,714,085,782.53
2.3.9 Хуримтлагдсан ашиг	6,033,511,677.43	6,263,555,660.64
<b>2.3.10 Эздийн өмчийн дүн</b>	<b>25,624,665,494.26</b>	<b>25,854,709,477.47</b>
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>37,029,636,345.28</b>	<b>35,557,341,805.13</b>

# Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлбар

Тайлант хугацаа : 2025-01-01 - 2025-12-31

/төгрөгөөр/

Үзүүлэлт

Өмнөх оны гүйцэтгэл

Тайлант оны гүйцэтгэл

1	Борлуулалтын орлого (Цэвэр)	23,894,295,918.89	25,423,475,974.10
2	Борлуулалтын өртөг	21,896,067,590.24	24,540,234,067.30
3	Нийт ашиг (алдагдал)	1,998,228,328.65	883,241,906.80
4	Түрээсийн орлого	164,107,952.36	270,865,888.72
5	Хүүний орлого	333,109,948.54	458,796,129.72
6	Ногдол ашгийн орлого	0	0
7	Эрхийн шимтгэлийн орлого	0	0
8	Бусад орлого	0	0
9	Борлуулалт маркетингийн зардал	0	0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,659,968,499.94	1,229,487,235.04
11	Санхүүгийн зардал	0	0
12	Бусад зардал	388,334,496.64	279,123,880.47
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-282,537,488.12	387,243,593.07
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,999,999.91	26,894,119.15
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0	0
16	Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0	0
17	Бусад ашиг (алдагдал)	0	0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	168,605,744.76	518,430,521.95
19	Орлогын татварын зардал	32,587,849.41	45,882,258.59
20	Татварын дараах ашиг (алдагдал)	136,017,895.35	472,548,263.36
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0	0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	136,017,895.35	472,548,263.36

# Аудитлагдсан өмчийн өөрчлөлт

Тайлант хугацаа : 2025-01-01 - 2025-12-31

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Харгасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гаргад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны ___-р сарын ___-ээрх үлдэгдэл</b>	<b>9,958,636,300.00</b>	<b>0</b>	<b>2,538,512,210.45</b>	<b>3,379,919,523.85</b>	<b>0</b>	<b>3,714,085,782.53</b>	<b>6,577,092,385.30</b>	<b>26,168,246,202.13</b>
Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0	-679,598,603.22	-679,598,603.22
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	0	2,538,512,210.45	3,379,919,523.85	0	3,714,085,782.53	5,897,493,782.08	25,488,647,598.91
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	0	0	136,017,895.35	136,017,895.35
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0	0	0
Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0	0	0
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0	0	0
<b>2024 оны 12-р сарын ___-ээрх үлдэгдэл</b>	<b>9,958,636,300.00</b>	<b>0</b>	<b>2,538,512,210.45</b>	<b>3,379,919,523.85</b>	<b>0</b>	<b>3,714,085,782.53</b>	<b>6,033,511,677.43</b>	<b>25,624,665,494.26</b>
Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0	0	0	-242,504,280.15	-242,504,280.15
Залруулсан үлдэгдэл	9,958,636,300.00	0	2,538,512,210.45	3,379,919,523.85	0	3,714,085,782.53	5,791,007,397.28	25,382,161,214.11
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0	0	0	472,548,263.36	472,548,263.36
Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0	0	0	0	0
Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0	0	0	0	0
Зарласан ногдол ашиг	0	0	0	0	0	0	0	0
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0	0	0	0	0
<b>2024 оны 12-р сарын ___-ээрх үлдэгдэл</b>	<b>9,958,636,300.00</b>	<b>0</b>	<b>2,538,512,210.45</b>	<b>3,379,919,523.85</b>	<b>0</b>	<b>3,714,085,782.53</b>	<b>6,263,555,660.64</b>	<b>25,854,709,477.47</b>

# Аудитлагдсан Мөнгөн гүйлгээ

Тайлант хугацаа : 2025-01-01 - 2025-12-31

/төгрөгөөр/

Үзүүлэлт

Өмнөх оны гүйцэтгэл

Тайлант оны гүйцэтгэл

1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	47,748,533,292.03	44,814,539,396.50
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	19,057,147,706.60	22,678,252,212.93
1.1.2	Эрхийн шимтгэл, хүлээн авсан мөнгө	0	0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0	0
1.1.4	Буцаан авсан албан татвар	0	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0	0
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	28,691,385,585.43	22,136,287,183.57
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	51,804,666,064.49	45,499,041,136.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн	9,263,002,414.59	10,112,043,395.37
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,600,292,451.72	2,870,220,812.17
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,116,829,696.22	2,094,119,848.65
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,527,248,679.55	3,595,269,651.78
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	0	0
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,264,220,533.57	3,187,074,513.74
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,569,937,639.86	2,205,769,393.73
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	84,999,772.09	9,725,738.77
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	25,378,134,876.89	21,424,817,782.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-4,056,132,772.46	-684,501,740.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	131,670,064.95	202,555,842.81
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0	0
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0	0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны	0	0
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	131,670,064.95	202,555,842.81
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0	0
2.1.8	ХО бусад мөнгөн орлого	0	0
2.2	Мөнгөн орлогын дүн (-)	1,367,339,065.00	985,382,839.52

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,280,905,165.00	737,948,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	86,433,900.00	247,434,039.52
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
2.2.5	Буцаан олгосон зээл болон урьдчилгаа	0	0
2.2.6	ХО бусад мөнгөн зарлага	0	0
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-1,235,669,000.05</b>	<b>-782,826,996.71</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>0</b>	<b>0</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	0
3.1.3	Төрөл бүрийн хандив	0	0
3.1.4	СҮА-ны бусад мөнгөн орлого	0	0
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>586,912,851.70</b>	<b>97,672,829.25</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0	0
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0	0
3.2.3	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0	0
3.2.4	Төлсөн ногдол ашиг	586,912,851.70	97,672,829.25
3.2.5	СҮА-ны бусад мөнгөн зарлага	0	0
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-586,912,851.70</b>	<b>-97,672,829.25</b>
<b>4</b>	<b>валютын ханшийн зөрүү</b>	<b>-522,533,345.84</b>	<b>761,266,239.87</b>
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-6,401,247,970.05	-803,735,326.39
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>16,148,550,148.05</b>	<b>9,747,302,178.00</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9,747,302,178.00</b>	<b>8,943,566,851.61</b>



МОНГОЛ  
ШУУДАН

Innovating for success  
**Newcom  
Group**

**ДРОН ХҮРГЭЛТИЙН ТУРШИЛТ**


*Хүргэлтийн ирээдүйг хамтдаа бийрвэе*








 TheMongolPost

 Монгол шуудан /Mongol Shuudan/

 [www.mongolpost.mn](http://www.mongolpost.mn)

## Монгол шуудан ХК

Сүхбаатарын талбай-9, ЧД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х-1106,  
Улаанбаатар-15160, Монгол улс

+976 1800-1613

[info@mongolpost.mn](mailto:info@mongolpost.mn)